

Becoming secure, strong
and independent

Family resources

Итгэл дүүрэн, хатуужилтай ба бие даан төлөвших

Гэр бүлд зориулсан материал

Сургуулийн Өмнөх Боловсролын бодлого (Early Years Learning Framework) нь цэцэрлэг болон бага насны хүүхдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын мөрдөх үндэсний хэмжээний боловсролын бодлого юм. Хүүхдийг зорилгот таван чиглэлээр сургаснаар тухайн хүүхэд сурах хатуужил, өндөр чадвартай болоход нь энэхүү бодлогын зорилго юм.

Сургалтын 1-р үр дүн бол хүүхдүүд өөрийгөө илүү таньж мэдэх тухай юм. Энэ нь хүүхдүүд өөрийнхөө хэн болох мөн өөрсдийнхөө соёлд итгэлтэй байхад тусалдаг. Хэрвээ хүүхдүүд өөрийн гэр бүл, хүрээлэл болон соёлын нэг хэсэг нь гэдгээ мэдэрч итгэл дүүрэн байж чадвал тэд аливаа зүйлийг сурахдаа ч өөртөө итгэлтэй байх болно.

Early Years Learning Framework-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах линкээр орж танилцана уу:
<https://www.acescqa.gov.au/nqf/national-law-regulations/approved-learning-frameworks>

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ цэцэрлэг эсвэл бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоорой. Хэрвээ утсаар холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны хүссэн дугаар руу залган мөн тухайн шугамд орчуулагчийг таньтай холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Сургуульд суралцах

Сургуулийн Өмнөх Боловсрол

Өөрийгөө илүү таньж мэдэх гэдэг нь:

Хүүхдүүд бусадтай хэрхэн хуваалцаж, тэднээс суралцан, мөн хүндлэх болон хамт байх тухай ойлгож мэднэ

Хүүхдүүд өөрийн гэр бүл, хүрээлэл болон соёлдоо тэдний нэг хэсэг нь гэдгээ мэддэг байна

Хүүхдүүд бүх зүйл хэвийн, тэд аюулгүй, мөн өөрчлөлт болон сэтгэл хөдлөлөө удирдаж чадна гэдэгтэй итгэлтэй байна

Хүүхдүүд өөрсдийгөө бусад хүмүүст, тухайн орон зайд болон өөрсдийн хөгжилд ямар нөлөөтэй гэдгээ мэддэг байна

Сурагчид соёлын олон бүлэгтэй харилцаж, холбоотой байна (Бүх сэдвийн хүрээнд)

Сурагчид ёс зүйн хүмүүжлийн тухай мэддэг болох ба мөн хувийн болон нийгмийн чадвараа хөгжүүлнэ (Бүх сэдвийн хүрээнд)

Сурагчид өөрсдийнхөө бие махбодын хөгжил болон эрүүл мэндээ сайжруулах тал дээр итгэлтэй болно (Сэдэв: Биеийн тамирын боловсрол)

Сурагчид бусад соёлын талаар олж мэдэн, хүндэтгэн тэмдэглэдэг болно (Бүх сэдвийн хүрээнд)